



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 744

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Зам тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Авто замын сан)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэрийн нийт 224,609,007.80 (хоёр зуун хорин дөрвөн сая зургаан зуун есөн мянга долоон төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Зам тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Х.Пүрэвжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007048
35-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 2 дугаар сарын 21-ны өдрийн
74 дугаар тогтоолын хавсралт



"ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ /АВТО ЗАМЫН САН/ -ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Мицубуши Пажеро 64-75 УББ	H76W0019324	1999/2017	6,500,000.00	1,200,000.00
2	Мицубуши Пажеро 49-04 УНН	JMYL RV93W9J000114	2008/2009	98,074,855.00	1,000,000.00
3	Мицубуши Пажеро 49-12 УНН	JMYL RV93W9J000122	2008/2009	96,991,902.80	2,000,000.00
4	Мицубуши Пажеро 64-73 УББ	H76W0107820	1999/2017	8,000,000.00	1,000,000.00
5	УАЗ-31512 07-97 УБН	50538497	2006/2006	12,654,000.00	1,000,000.00
6	Тоёото Ландкрузер- 105 20-89 УБГ	JTECB09J623006093	2002/2002	2,388,250.00	8,000,000.00
Нийт дүн				224,609,007.80	14,200,000.00
				(хоёр зуун хорин дөрвөн сая зургаан зуун есөн мянга долоон төгрөг наян мөнгө)	(арван дөрвөн сая хоёр зуун мянга)